



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 6/06

Чингис хот

Б.Наранбаярыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.3.2, "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын 2.2.1, 3.1, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц, төлөвлөлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн Б.Наранбаяр нь урт хугацааны сургалтад хамрагдах болсон тул 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Б.Наранбаяртай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------|---------------|--|
| Комиссын дарга: | Э.Мөнх-Эрдэнэ | -Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Ц.Бат-Эрдэнэ | -Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн |
| | Т.Баяртуяа | -Аж ахуйн нярав |

4. Б.Наранбаярыг төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР